МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 28 өдөр Дугаар А/616 Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн
төлөөлөгч томилж, ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.6, 46.3, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол "Журам батлах тухай", Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаал "Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай", аймгийн Засаг даргын 2022 оны А/95 дугаар "Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай" захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар "Хүүхдийн өрөө"-ний тавилга, тоног төхөөрөмж худалдан авах /Шүүхийн Тамгын газар/ гүйцэтгэгч сонгох ХӨАОНӨГ/202307151 дугаартай тендерт 29,500,000 (Хорин есөн сая таван зуун мянган) төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Дөш Ган" хоршооны тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. "Дөш Ган" хоршоотой гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, нийлүүлэх барааны чанар байдал, гэрээний нөхцөлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий "Захиалагчийн төлөөлөгч"-өөр Хөвсгөл аймаг дахь шүүхийн Тамгын газрын дарга (Б.Амартүвшин)-ийг томилж, бараа, үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Амартүвшин (Хөвсгөл аймаг дахь Шүүхийн Тамгын газрын дарга)
Ажлын хэсгийн гишүүд: Х.Цэнд-Аюуш (Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Ц.Пүрэвээ ("Дөш Ган" ХХК-ийн захирал)
А.Энхжаргал (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын нутгийн захиргаа байгууллагын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн)
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: П.Хажидмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Мэдээлэл технологи дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн)

3. "Хүүхдийн өрөө"-ний тавилга, тоног төхөөрөмж худалдан авах /Шүүхийн Тамгын газар/ бараа нийлүүлэх гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, барааг (үйлчилгээг) хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын

үр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон орон нутгийн архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч (Б.Амартүвшин)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, бараа (үйлчилгээ) хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг хуульд заасан бусад баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон Орон нутгийн өмчийн газрын архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Төмөр)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ